



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 65

Мөрөн

**Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж,
хариуцлага тооцож ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагаын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 32 дугаар зүйлийн 32.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 56 дугаар зүйлийн 56.1, Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 Аймгийн Аудитын газрын “Мөрөн сумын газар, олголт, ашиглалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчин газар олгосон, мөн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулалгүй иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлсэн зэрэг хууль бус шийдвэрийг удаа дараа гаргасан Аймгийн Засаг дарга, Мөрөн сум Засаг дарга нарыг Монгол Улсын Газрын тухай, Хот байгуулалтын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж дүгнэсүгэй.

2. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гүйцэтгэлийн аудитын тайланд дурьдагдсан зөрчилтэй холбогдох нэр бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллахыг /аймгийн Засаг дарга/ А.Эрдэнэбаатар, /аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга/ Н.Бямбадорж нарт даалгасугай.

3. Аймгийн Аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангаж, үр дүнг 2015 оны 12 дугаар сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг /аймгийн Засаг дарга/ А.Эрдэнэбаатар, /Мөрөн сумын Засаг дарга/ Ц.Гансүх, /аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга/ Н.Бямбадорж нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Т.БОЛДБААТАР